



АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2025.06.05

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а) байгууллагын албан ёсны цахим хуудас; b) сошиал сувгууд; c) дотоод сүлжээ; d) хэвлэл мэдээллийн хэрэгсэл; e) мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц; f) бусад /салбар байгууллагууд/ хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүртэл;	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн инфографик, зурагт хуудсыг албан ёсны цахим хуудсанд байршуулж нийгмийн даатгалын газрын албан хаагчдад сурталчлан ажиллаа. 62 лайк, 28 шейр хийсэн байна. 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Хуульчдын про боно өдөрлөгт оролцож, “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” соён гэгээрүүлэх аян, Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс зохион байгуулж эхлүүлсэн. Өдөрлөгт Нийгмийн даатгалын газар иргэд, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмжийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа. Нийт 50 гаруй иргэд, даатгуулагчид хамрагдлаа. “Авлигын эсрэг нэгдье” контент хийж олон нийтэд хүргэлээ.  

1.2.Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах. /2-оос доошгүй/	2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Хуульчдын про бано өдөрлөгт оролцож, “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” соён гэгээрүүлэх аяны нээлтийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс зохион байгуулж эхлүүлсэн. Энэ өдөрлөгт Нийгмийн даатгалын газар иргэд, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмжийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа. Нийт 50 гаруй иргэд, даатгуулагчид хамрагдлаа.
1.3.Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах.	Өөрийн байгууллагын пэйж хуудас болон харилцагч иргэд, даатгуулагчдад Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээллэн сурталчлах 110 утасны дугаарыг оруулсан зурагт хуудсыг харагдахуйц газар байршуулан сурталчлан ажиллаж байна. 
1.4. Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс	Тус газрын иргэдэд үйлчлэх хэсэгт “Авлигыг мэдээл 110 ” утасны брошур хэвлэмэл хуудсыг байцаагч бүрийн цонхонд иргэдэд ил тод харагдахуйцаар байршуулсан. Мөн сошиал цахим хуудас, болон мэдээллийн самбартаа авлигын эрсдэлээс

		зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж олон нийтэд хүргэсэн байх.	ангид байлгахад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент, постер зурагт хуудсыг байнга шинэчлэн байршуулж ,түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах ажлыг тогтмол хийж байна. “Аливаа юманд ижил тэгш хандвал нийгэмд шударга ёс тогтоно” хэвлэмэл хуудсыг байгууллагынхаа мэдээлэх самбарт байршуулсан .
2	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	2.1.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх. Аймаг орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын жагсаалтыг гарган, уулзалт зохион байгуулж, тулгамдаж буй асуудлаа хэлэлцэх, шаардлагатай тохиолдолд Авлигатай тэмцэх газраас цахимаар зөвлөмж авч ажиллах. 2.2. Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах.	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр аймгийн нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдтэй Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс ZOOM хурлыг зохион байгуулж эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн гишүүд 100 хувь хамрагдлаа.   Тус газар нь 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн саналд Нийгмийн даатгалын газрын барилгын конторын өргөтгөлийн барилгын зураг, төсөв өртөгийг төлөвлөж, төлөвлөлтийн мэдээллийг https://pimis.publicinvestment.gov.mn/#/login цахим сайтад ил тод мэдээллийг оруулсан. Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, сангийн болон үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг батлагдсан маягтын дагуу сар, улирал бүр мэдээг НДСан тус бүрээр нь гаргаж хуулийн хугацаанд нь тогтмол мэдээллэж ажилласан. Үүнд: НДС, НДГ-ийн үйл ажиллагаатай

		холбоотой /Бусад мэдээлэл -20, худалдан авалт -14, төсвийн гүйцэтгэлийн -22/ мэдээллийг тайлагнасан байна.
	2.3.Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хагас, бүтэн жилээр тайлагнах, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших.	Газрын даргын 2024 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн А/01 тоот тушаалаар байгууллагын “Ёс зүйн дэд хороо”-г шинэчлэн байгуулан ажиллаж байна. Ёс зүйн дэд хороон 1 дарга, 1 нарийн бичгийн дарга, 4 гишүүнтэй. Газрын албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар онлайн сургалт 1 удаа, “ Төрийн албан хаагчийн ёс зүй ” сэдвээр Нийгмийн хамгааллын салбарын ажилтан, албан хаагчдад танхимаар 1 удаа сургалтыг зохион байгуулж газар, сумдын нийт 30 байцаагч ажилчид хамрагдлаа. 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно.Ёс зүйн талаарх хууль тогтоомжуудыг өөрийн байгууллагын цахим хуудсанд тогтмол байршуулж ажиллаад байна.



			2025 оны хагас жилийн байдлаар хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээлэл тус байгууллагад ирүүлээгүй байна.
3	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	3.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухай байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах.	Нийгмийн даатгалын байгууллага нь 34 төрлийн үйлчилгээг ажил олгогч, иргэд даатгуулагчдад үзүүлдэгээс 24 үйлчилгээг цахимжуулсан. Үүнээс 18 үйлчилгээг E-Mongolia цахим системийн нэгдсэн порталд холбогдож лавлагаа мэдээллийг авч байна.Тухайлбал:Тэтгэмжийн даатгалын сангаас олгогддог хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, жирэмсэн болон амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын сангаас олгодог ажилгүйдлийн тэтгэмжүүд цахим хэлбэрт шилжээд байна. Байгууллагын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээг http://daatgal.ar.gov.mn/ , нийгмийн даатгалын албан ёсны page хуудас, байгууллагын мэдээллийн самбарт ил тод байршуулсан. Мөн www.shilendans.gov.mn Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмыг ажилдаа мөрдлөг болгон ажиллаж www.shilendans.gov.mn , байгуулллагын www.ndaatgal.ar.gov.mn мэдээллийн сайтад Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, сангийн болон үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийн 40 төрлийн мэдээ, мэдээллийг батлагдсан маягтын дагуу шилэн дансанд нээлттэй, ил тод 5 удаа байршуулж ажиллаа.
		3.2.Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх.	Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны “Журам, маягт, жагсаалт, шинэчлэн батлах” 05 дугаар тогтоолын хавсралтаар “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ын маягт, “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ын маягт, “Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарын маягт”-ийг тус тус батлагдаж 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс дагаж мөрдөж ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2024 оны 5 дугаар сарын 10 дугаар хавсралтаар Нийгмийн даатгалын газрын байцаагч, мэргэжилтний албан тушаалтын тодорхойлолт “ТЗ-6”, “ТЗ-7” зэрэглэлээр баталсан. 18 байцаагчийн 2025 оны “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ыг гаргуулсан байна.

